

Гарчиг

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3
1.1 Төслийн нэр	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгч	3
1.3 Төсөл хэрэгжих талбайн байршил	3
1.4 Төслийн хүчин чадал	4
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ	7
2.1 Байршил	7
ГУРАВ. УУР АМЬСГАЛ	7
3.1 Уур амьсгалын онцлог.....	7
3.2 Улаанбаатар хот орчмын цаг уурын хэмжигдхүүний үндсэн горим, нөхцөл	7
3.3 Температурын горим.....	7
3.4 Агаарын даралт, салхины онцлог.....	8
3.5 Хур тунадас.....	8
ДӨРӨВ. АГААРЫН ЧАНАР	9
4.1 Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд	9
4.2 Агаарын чанарын ерөнхий төлөв байдал.....	9
ТАВ. ФИЗИК БОХИРДОЛ.....	10
5.1 Хог хаягдлын тооцоо	10
5.1.1 Төслийн ахуйн хэрэглээнээс үүсэх хог хаягдал	10
5.1.2 Төслийн технологи үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал	10
ЗУРГАА. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	11
6.1 Төслийн болзошгүй нөлөөлөл.....	11
ДОЛОО БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
7.1 Зорилго	12
7.2 Зорилт.....	12
7.3 Хамрах хүрээ:	12
7.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
7.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	14
7.6 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	14
7.7 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал.....	15
7.8 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	17

Зургийн жагсаалт

Зураг 1 .Төсөл хэрэгжих талбайн байршил./Google Earth/	3
Зураг 2 Үйлдвэрийн байр.....	4
Зураг 3 Үйлдвэрийн дотоод зам талбай, авто машины зогсоол	4
Зураг 4 Үйлдвэрийн оффис, ажилчдын хувцас солих өрөө	5
Зураг 5 Бүтээгдэхүүн хадгалах хөргөлттэй зоорь	5
Зураг 6 Үйлдвэрийн дотор тал, тоног төхөөрөжлийн хэсэг.....	5
Зураг 7 Үйлдвэрийн дотор тал, тоног төхөөрөжлийн хэсэг.....	6

Зураг 8 Үйлдвэрийн дотор тал, тоног төхөөрөжлийн хэсэг.....	6
Зураг 9 Ууурын зуух болон сайжруулсан түлшний агуулах.....	9

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Хэмжилтийн дүнгийн хуудас	9
Хүснэгт 2 Үйлдвэрийн технологийн хатуу хог хаягдлын хэмжээ улиралаар	10

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн нэр

Мах боловсруулах үйлдвэр

1.2 Төсөл хэрэгжүүлэгч

“Гангар Хос Вансэмбэрүү” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9019097235

Регистрийн дугаар: 6655408

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 23-р хороо, Улиастай 5-р хэсэг 1346

Утас: 77485575, 99060015


Төсөл хэрэгжүүлэгч “Гангар Хос Вансэмбэрүү” ХХК нь “Эх Хөгжил” ХХК-тай үйлдвэр түрээсийн гэрээ байгуулан үйлдвэрийн байр болон тоног төхөөрөмжийг ашиглан мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Төслийн зорилго:

- Ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс бүтээгдэхүүний чанар, онцлог байдлаар давуу талыг олж авах,
- Өөрийн зэргэлдээ орших үйлдвэрээс баталгаатай, чанартай түүхий эд бэлтгэн, бүтээгдэхүүний нэгжийн өртгийг бууруулах
- Эрүүл ахуй, чанарын шаардлагыг бүрэн хангаж ажиллан, байгаль орчинд хор нөлөөгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх,

1.3 Төсөл хэрэгжих талбайн байршил

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 23-р хороонд Улиастай 5-р хэсэг 1346 тоот



Зураг 1 .Төсөл хэрэгжих талбайн байршил./Google Earth/

1.4 Төслийн хүчин чадал

- Бод мал- 400 / нэг ээлжиндээ 60тн /
- Бог мал- 2000 /нэг ээлжиндээ 50тн /
- Хүйтэн хадгалалт / 2000 тн /
- Муур нохойн хоол тэжээл

Үйлдвэрийн байрны дотоод бүтэц:

- Үйлдвэрлэл явагдах байр / тоног төхөөрөмж суурьлагдана /
- Мах болон дайвар бүтээгдэхүүн, тэм-н агуулах
- Сав баглаа боодлын агуулах
- Чанар шалгах бүхийн +40 хэмийн агуулах
- Бэлэн болсон бүтээгдэхүүн хадгалах агуулах
- Ажилчдын хувцасны өрөө
- ОО /эр, эм /



Зураг 2 Үйлдвэрийн байр



Зураг 3 Үйлдвэрийн дотоод зам талбай, авто машины зогсоол



Зураг 4 Үйлдвэрийн оффис, ажилчдын хувцас солих өрөө



Зураг 5 Бүтээгдэхүүн хадгалах хөргөлттэй зоорь



Зураг 6 Үйлдвэрийн дотор тал, тоног төхөөрөжлийн хэсэг



Зураг 7 Үйлдвэрийн дотор тал, тоног төхөөрөжлийн хэсэг



Зураг 8 Үйлдвэрийн дотор тал, тоног төхөөрөжлийн хэсэг

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

2.1 Байршил

Улаанбаатар хот Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт, тухайлбал Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд шувтрага үзүүрт Туул голын өргөн хөндий, ай сав цутгал голуудын бэлчирт байрладаг.

Улаанбаатар хот далайн төвшнөөс дээш 1350 метр өндөрт Номхон далайгаас 1600 орчим км алсад, Дэлхийн экватороос хойш 5310 км, хойд туйлаас урагш 4690 км зайтай буюу дэлхийн хойд өргөрөгийн 47°55', зүүн уртрагийн 106°55'-ын солбицолд, дэлхийн цагийн 7 дугаар бүсэд Лондон хотоос 7 цаг 08 минутын зөрөөтэй оршиж байна.

Улаанбаатар хот урдуураа Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг, баруунаараа мөн аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянцогт, баруун хойгуураа мөн аймгийн Батсүмбэр, зүүн хойгуур, зүүгээрээ мөн аймгийн Батсүмбэр, Эрдэнэ сумтай хиллэн нийт 470444 га талбай бүхий нутаг дэвсгэрийг эзэлдэг.

ГУРАВ. УУР АМЬСГАЛ

3.1 Уур амьсгалын онцлог

Нийслэл Улаанбаатар хотын байршил Хан-Хэнтийн нурууны салбар уулсын дундах “Хүн чулууны хотгор”-т байршиж, Туул голын өргөн уудам хөндий түүний цутгал цөөнгүй голын хөндий бүхий дэнж, уулын бэл, хажуу бүхий рельефтэй. Монгол орны физик газарзүй буюу дэвсгэр гадарга нь байгалийн болон уур амьсгал, тэр тусмаа Улаанбаатар хот, хот орчмын нутаг дэвсгэр нөгөө талаас хот, хотын элемент, хүний хүчин зүйлийн үйл ажиллагаа нь агаарын бохирдол болон бичил (микро), бэсрэг (мезо) уур амьсгалын цоо шинэ хүчин зүйлийг бий болгодог онцлогтой.

3.2 Улаанбаатар хот орчмын цаг уурын хэмжигдхүүний үндсэн горим, нөхцөл

Нарны цацраг, дулаан хүйтний нөхцөл: Нийслэл Улаанбаатар хот орчмын уур амьсгал бүрдүүлэгч үндсэн хүчин зүйлийн нэг нарны цацраг, нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа нь орон нутгийн онцлогтой боловч бүсийн горимыг дагадаг. Жилдээ хэвтээ гадаргад дунджаар ирэх нийлбэр цацраг 4716.2 мДж/м², шулуун цацраг 2761.4 мДж/м² ба нарны өндөр хамгийн бага байх өвлийн сар, өдрүүдэд бага (нийлбэр цацраг XII сард 134.7 мДж/м²) байснаа алгуур нэмэгдэж V-VI сард нийлбэр цацраг 604.8-614.3 мДж/м² болтлоо өсч, улмаар үүлшил, нарны өндөртэй уялдан буурч намар болон өвлийн горимд шилжиж байдаг гийгүүллийн үргэлжлэх хугацаа жилдээ 2600-3100 цаг, ердөө 16-27 өдөр л наргүй өдөр тохиож байдаг. Нарны гийүүлэл сар, улирлын явцтай. Хүйтний улиралд 170-220 цаг байдаг ба нар буцах цаг хүртэл өсдөг бөгөөд зуны улиралд хамгийн их утгандаа хүрч 290-320 цаг заримдаа бүр 360 цаг нар гийгүүлнэ. Энэ нь нийт боломжит гийгүүллийн 66 хувийг эзэлнэ.

3.3 Температурын горим

Дулаан, хүйтний горимыг авч үзэхэд өвлийн улирлын дундаж температур -16.7°C...-25.2°C, зуны улирлын дундаж 15.5°C-ээс 18.3°C-ийн хооронд хэлбэлздэг. Жилийн дундаж температур -3.1°C...1.5°C, хоногийн үнэмлэхүй их температур VII сард +38°C...+39.5°C хүрч халдаг бол үнэмлэхүй бага температур I сард -40°C-ээс -46.7°C хүрч хүйтэрдэг.

Улаанбаатар хотод агаарын температур өвлийн эхэн болон төгсгөлд огцом хүйтэрч, дулаардаг байна. Тухайлбал II сарын сүүлчээс III сарын эхний 10 хоногт шилжихэд арав хоногийн дундаж температур 4.0°C-ээр дулаарч, XI сарын эхний болон хоёрдугаар арав хоногийн хооронд 4.1°C-ээр хүйтэрдэг.

Агаарын температурын хоногийн явцаас үзвэл хоногийн температурын явц сар, сард болон хотын янз бүрийн хэсэгт ялгаатай юм.

3.4 Агаарын даралт, салхины онцлог

Нийслэл Улаанбаатар хот орчимд өвлийн улиралд эсрэг циклоны их даралтын нөлөөн дор агаарын даралтын их утга ажиглагдаж, салхигүй тогтуун, дулааны улиралд агаар мандлын бага даралтын орон түүний харьцангуй их утга ажиглагддаг. Агаарын даралтын хуваарилалтаас салхи үүсч, улмаас уулзүйн онцлогоос хамаарч хуваарилагдана. “Буянт-Ухаа” станцын мэдээгээр Улаанбаатарт далайн түвшинд шилжүүлсэн даралт жилийн дунджаар 1022.1 гПа байх бөгөөд сарын дундаж даралт зун хамгийн бага (1004.2 гПа), өвөл хамгийн их (1042.2 гПа) байдаг.

Салхины зүг Улаанбаатар хот орчим хотын янз бүрийн хэсэгт болон сар, улирал, хоногоор ихээхэн ялгаатай. Өвлийн улиралд энэ зүгийн салхины давтагдал 53.0% болж илт давамгайлна. Зун энэ зүгийн салхи хамгийн бага 19.0% болтол буурах боловч намар дахин ихэсдэг. Энэ нь Богд уулын ар дагасан хажуугийн салхи юм. Өвөл шөнийн хугацаанд энэ зүгийн салхины давтагдал бүр ч өсч байгаа явдал үүний нотолгоо болно. Тухайлбал зүүн өмнөдийн салхи өвлийн өдөр шөнөөсөө хоёр гаруй дахин буурч, харин хойд болон баруун хойд зүгийн салхи нэмэгддэг. Харин “Улаанбаатар” станц буюу хотын баруун талд жилийн дунджаар баруун хойд зүгийн салхи 47.3%-ийн давтагдалтай зонхилох боловч зүүний салхи 15.9% байгаа нь зэргэлдээх зовхисоосоо хавьгүй их давтагдалтай байна. Ялангуяа III-IV сард энэ зүгийн салхи 13.0-14.3% болж зонхилох зүг болдог. Энэ зүгийн салхины давтагдал хаврын сүүл сард нилээд буурах боловч зуны саруудад ахин нэмэгддэг.

3.5 Хур тунадас

Манай орны хур тунадасны горимын нэг онцлог бол жилийн дулааны улиралд хур тунадас их, харин хүйтний улиралд хур тунадас бага унадаг. Хур тунадасны горим даралтын орны үйлчлэлээр тодорхойлогдох боловч дулааны улиралд орон нутгийн дулааны конвекцийн нөлөө их байна. Хур тунадасны 85 орчим хувь жилийн дулааны улиралд (IV-IX сард) үүнээс зөвхөн VII, VIII сард 50- 60% нь ордог. Жилд дунджаар 240 мм тунадас орох ба үүний 90%-ийг шингэн хур тунадас нь эзэлдэг.

Харьцангуй чийгшлийн хэмжээ агаарын температураас ерөнхийдөө урвуу хамааралтай ба үүл, хур тунадаснаас мөн хамаарна. Харьцангуй чийгшил Улаанбаатар хотын хувьд өвлийн саруудад их 70-73%, хавар IV-V сард бусад саруудаас харьцангуй бага 44-46% болж өвлийнхөөс бараг 30%-иар буурдаг. Зуны саруудад унах хур тунадасны тоо хэмжээ нэмэгдсэнээр хөрсний чийг өсч, улмаар ууршилт ихэссэнтэй холбоотойгоор агаарын чийгшил нэмэгдэнэ. Жилд 40-70 өдөр бороотой, 25-30 өдөр цастай, 140-170 өдөр цасан бүрхүүл тогтоно. Цасан бүрхүүлийн нягт 0.17- 0.23 г/м³, түүний нөөц услаг 10-17 мм хүрнэ.

ДӨРӨВ. АГААРЫН ЧАНАР

4.1 Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд

Төслийн нутаг дэвсгэр, талбайн орчимд үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн аж ахуй нэгжүүд байдаг ба эдгээр төслийн үйл ажиллагаанаас агаарт нөлөөлөх нөлөөллийн хувьд гол төлөв тоос болоод тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс хаягдах утаа, үйл ажиллагаанаас гарах эвгүй үнэр, хог хаягдлын цэгийн замбараагүй байдлаас үүсэх үнэр нь агаарын чанарт нөлөөлж болзошгүй. Тээврийн хэрэгслээс гарах утаа нь нүүрстөрөгчийн дутуу исэл, давхар исэл, азотын дутуу исэл, давхар исэл хар тугалга, хүхэрлэг хий зэрэг хорт бодисуудыг ялгаруулдаг.

Харин зам талбайд тоос бий болох нь агаар дахь том, жижиг ширхэглэгт тоосонцрын агууламжийг нэмэгдүүлж агаарыг бохирдуулж болзошгүй. Агаарын чанарт нөлөөлөх эх үүсвэр нь салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

4.2 Агаарын чанарын ерөнхий төлөв байдал

Төслийн талбай нь агаарын чанар дунд зэрэг, ойр орчимд гал түлдэг айл өрхүүд байрладаг учир өвлийн улиралд утааны бохирдол үүснэ. Төслийн үйл ажиллагаанд уурын зуух ашиглан сайжруулсан түлш ашиглана.



Зураг 9 Уурын зуух болон сайжруулсан түлшний агуулах

Агаар бохирдуулагч бодисууд болох хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл, том ба нарийн ширхэглэгт тоосонцрын дунд зэргийн бохирдолтой. Мах боловсруулах үйлдвэр байрлах талбайгаас БОХЗТ Лабораторийн техникч дээж аван шинжилгээ хийсэн бөгөөд утааны хийн агууламжийн шинжилгээний дүнг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1 Хэмжилтийн дүнгийн хуудас

Он сар өдөр:	2021.03.27			
Эзэмшигчийн нэр:	Гангар Хос Вансэмбэрүү ХХК			
Түлшний төрөл:	Багануур			
Хэмжилт хийсэн газрын нэр:	Баянзүрх дүүрэг 23-р хороо			
Хэмжилт хийсэн огноо:	2021.03.23			
Үзүүлэлт	NOx мг/м³	SO2 мг/м³	CO мг/м³	TSP мг/м³
Утааны хийн агууламж	36	378	6395	671
MNS 5043:2016 стандарт	450	800	5000	600

ТАВ. ФИЗИК БОХИРДОЛ

Төсөл хэрэгжих талбайн орчинд доргио чичиргээ, цацраг идэвхит бохирдлын эх үүсвэр байхгүй. Иймд тус орчинд ямар нэгэн физик бохирдлын эх үүсвэргүй, физик бохирдолгүй байна. Харин ойр орчимд барилгын ажил явагдах, авто зам дагуух хөл хөдөлгөөн ихсэх, хүмүүсийн бөөгнөрөл бий болох зэргээс дуу чимээ ихсэх магадлалтай.

Төслийн үндсэн үйл ажиллагааны үед гол төлөв ахуйн шинжтэй, ажилчид хэрэглээ, үйлдвэрийн технологийн явцад гарах яс, цус, өөхний хаягдал гарахаар байна.

5.1 Хог хаягдлын тооцоо

5.1.1 Төслийн ахуйн хэрэглээнээс үүсэх хог хаягдал

Энгийн хог хаягдал – Энгийн хог хаягдлын дийлэнх хувийг ахуйн хог хаягдал бүрдүүлнэ. Ажилчдын өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн гаралтай хог хаягдлууд болох хоол хүнсний үлдэгдэл, материалын сав баглаа боодол цаас, пластмасс, төмөр, шил, мод зэрэг хог хаягдлууд гарна.

Хог хаягдлыг зайлуулах арга хэмжээ

Энгийн хог хаягдал - Төсөл хэрэгжүүлэгчид энгийн хог хаягдлыг дараах байдлаар зайлуулах, мөрдөж ажиллаж байна.

1) “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ажиллаж байна.

2) Хог хаягдлын ангилан ялгалтыг сайтар хийж, хогийн сав байршуулалт сайн, тэмдэг тэмдэглэгээг стандарт шаардлагад нийцүүлэн ажилтан албан хаагчдад шууд харагдахуйц байрлалд байрлуулж, ажилчид албан хаагчид тухайн шаардлага хангахад гар бие оролцох эь зүйтэй.

3) Баянзүрх дүүргийн ТҮК-тай хамтран ажиллах гэрээтэй. Гэрээний дагуу тогтсон хугацаанд ахуйн хог хаягдлаа ачиж зайлуулдаг.

5.1.2 Төслийн технологи үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал

Үйлдвэрээс гарах технологийн хаягдал:

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас цаасан хайрцаг, гялгар уут, хуванцар сав, бусад жижиг хог хаягдал зэрэг хаягдлууд гардаг. Дараах хүснэгтээр харуувал:

Хүснэгт 2 Үйлдвэрийн технологийн хатуу хог хаягдлын хэмжээ улиралаар

Үйлдвэрийн нэр	Хаягдлын төрөл	Хаягдлын хэмжээ /кг/	Хаягдал зохицуулалт
Махны үйлдвэрийн хог хаягдал	Цаасан хайрцаг	-	Экопак цаасан хайрцагны үйлдвэрт
	Гялгар уут	-	Эко сити селешин компанид
	Дахин боловсруулагдах боломжгүй хог хаягдал	-	ТҮК
	Хаягдал яс /сард дунджаар 0,3тн/	0,9	Өгий гранд ХХК
	Хаягдал мах /сард дунджаар 0,05тн/	0,15	Дотоодын борлуулалтаар
	Хаягдал өөх	-	Натурал Грасс Ланд ХХК

Үйлдвэрээс гарч байгаа хог хаягдлыг дахин ашиглах тал дээр төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс онцгой анхаарч ажиллаж байна.

ЗУРГАА. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

6.1 Төслийн болзошгүй нөлөөлөл

Төслийн болзошгүй нөлөөллийг БОННУ-ний тайлангаас татан оруулав.

Шууд нөлөөлөл: Үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөл нь ихэвчлэн шууд нөлөөлөл байна. Болзошгүй нөлөөлөлд нийт 33 зүйлийг авч үзсэн бөгөөд шууд нөлөөлөлд 25 зүйл багтаж байна. Эдгээр нөлөөлөлд гүний усны өөрчлөлт, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл зэрэг байгаль экосистемийн өөрчлөлтөд нөлөөлөх нөлөөллүүд багтана. Ахуйн болон технологийн хатуу хог хаягдал, машин техникийн шатах тослох материалын нэвчилтээс хөрсний чанарт нөлөөлөх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бий болох тоос, хөдөлгүүрээс ялгарах утаанаас агаарын чанарт нөлөөлөх, хөрс бохирдох, эвдрэх, дуу чимээ тархах зэрэг нөлөөллүүд хамрагдана. Эдгээрээс гадна төслийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн тээвэрлэх ачиж буулгах явцад хөрс элэгдэж эвдрэх, хог хаягдлыг зайлуулаагүй удсанаас орчинд эвгүй үнэр тархах, ялаа шавьж үржих, олон салаа зам гарах, галын аюулгүй байдал алдагдах, бохирын цооног цоорох, гэмтэх зэрэг болзошгүй сөрөг нөлөөллүүд хамаарна.

Өөрөө зохицуулагдах: Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь тархах хүрээ хомс, нөлөөллийн хэмжээ бага, эрчим нь сул, салхиар зөөгдөн замхрах шинж чанартай тул өөрөө зохицуулагдах гэж авч үзлээ. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах уурын зуухнаас гарах утаа нь агаарын бохирдлын гол эх үүсвэр болох бөгөөд уурын зуухны янданд шүүлтүүр тавих, утааны хийн агууламжийг байнга хянаж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй ажиллах шаардлагатай юм.

Богино хугацааны нөлөөлөл: Үүнд 12 зүйл багтах бөгөөд гадаргын усанд нөлөөлөх, бичил уур амьсгалын өөрчлөлтөнд нөлөөлөх, , хог хаягдлын зайлуулалт, хөрс элэгдэх, хөл хөдөлгөөн ихсэх, бохирын цооногийн бүрэн бүтэн байдал алдагдах, гал түймэр гарах, байгалийн гамшигт үзэгдлээс үүдэн бий болох нөлөөллүүд багтана.

Дунд хугацааны нөлөөлөл: Энд агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл, барилга байгууламж барих үеийн нөлөөлөл, нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллүүдийг хамааруулав.

Урт хугацааны нөлөөлөл: Урт хугацааны нөлөөлөлд 11 зүйл багтаж байгаа нь гүний ус, хөрс, ургамал, амьтдын орон зайн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт зэрэг нөлөөлөл орж байна.

Буцах нөлөөлөл: Хог хаягдлын хадгалалт зайлуулалтыг удааснаас орчинд эвгүй үнэр тархах, ялаа шавьж үржих, гал түймэр гарах зэргээс шалтгаалан хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол үзүүлж болзошгүй үр дагавартай тул буцах чиглэлийн нөлөөл болно.

Буцалтгүй нөлөөлөл: Тухайн орон зайд барилга байгууламж баригдаж, идэвхитэй үйл ажиллагаа яваагддаг тул хөрс, ургамал, газрын гадаргад буцалтгүй нөлөө үзүүлнэ. Мөн байгалийн унаган төрх болон ландшафтын өнгө төрх өөрчлөгдөх нь буцалтгүй нөлөөлөл болно. Тиймээс төслийн үйл ажиллагаа явагдах бүхий л үе шатанд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байхаар төлөвлөх, менежмент боловсруулан ажиллах хэрэгтэй.

Хүчтэй нөлөөлөл: Нийт нөлөөллийн 5 зүйл нь хүчтэй нөлөөлөлд багтаж байна. Үүнд хөрсөн бүрхэвч элэгдэж эвдрэх, талхлагдах, шугам хоолойн бүрэн бүтэн байдал алдагдах, гал алдах, байгалийн гамшигт үзэгдлээс үүдэн бий болох нөлөөлөл багтаж байна. Нөлөөлөлд хамгийн ихээр өртөх байгалийн бүрэлдэхүүн хэсэг нь хөрсөн бүрхэвч байна.

Дунд эрчмийн нөлөөлөл: Энд нийт 16 зүйл багтах бөгөөд төслөөс гүний усны ашиглалт, нөөц, хэмжээ, гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл, ургамлан нөмрөгийн өөрчлөлтөд

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Тухайн жилийн зардал/мян.төг/
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1 420.0
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/	-
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6.	Осол, Химийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500.0
7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	370.0
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	270.0
Нийт		2 560.0

нөлөөлөх зэргээс гадны нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг талын нөлөөллүүд багтана.

ДОЛОО БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

7.1 Зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

7.2 Зорилт

1. БОННУ-гээр тодорхойлогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэн, бууруулах арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажиллах
2. Харъяа нутаг дэвсгэрийн иргэдтэй нээлттэй харилцаж, байгаль орчинд халгүй нөхцлийг бүрдүүлж хамтран ажиллах
3. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, нутгийн иргэд болон засаг захиргааны нэгжүүдтэй нягт уялдаатай ажиллах зорилтуудыг тавьж ажиллана.

7.3 Хамрах хүрээ:

Төслийн талбай буюу түрээслэн ашиглах үйлдвэрийн байр, хашаанд хамаарна.

7.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7		
1	Хөргүүрт ашиглах хөргөлтийн бодис	Орчны болон ажлын байрын агаарын бохирдлын байдалд жилд 2 удаа шинжилгээ хийлгэх /2-3 цэгт/	Үйлдвэрийн хүрээнд	удаа	35.0	2 цэгт 1 удаа	70.0	2022 он	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
2	Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ.	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Ажиллагсад	удаа	8.0	26 хүн, жил бүр	200.0		MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм-түвшний хэмжээ
3		Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийх.	Агуулах, үйлдвэрийн байранд, хашаанд	удаа	30.0	2 цэгт жилд 1 удаа	70.0		
4	Усны нөөцөд сөрөг нөлөөлөх, эрүүл ахуйн шаардлага хангагдахгүй байх	Усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг төлөх	Төслийн хүрээнд	--*--	--*--	--*--	--*--		- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, - Усны тухай хууль
5	Ахуйн бохирдол үүсэх	Үйлдвэрийн байрны гадна хог хаягдлыг хадгалах зориулалтын битүүмжилсэн хогийн савны сайжруулалт хийх, ангилан ялгалттай болох	Агуулах, төвийн хогийн цэгт	--*--	--*--	--*--	1,000.0		MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7		
6		Хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байх	Төслийн хүрээнд	---*	---*	---*	---*	2022 он	бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
7	Ахуйн гаралтай хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох.	Үйлдвэр, агуулахын гадна орчинг зүлэгжүүлэх, мод тарих, хог хаягдлын ангилан ялгалтыг байнга хянаж ажиллах	Үйлдвэрийн эргэн тойронд	ш	6.5	5	80.0		

*- “Улаанбаатар хотын 2020 онд тарилтад тэнцэх мод сөөгийн тарьц, суулгацын ААНБ-ын судалгаа” “Тоонот байгаль” ТББ-ын үнийн дүнгээр авав.)

7.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төслийн талбай нь аймгийн төвд, суурьшлын бүсэд байрлах учир нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

7.6 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6		
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн болон шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх.	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Барилга байгууламж техник тоног төхөөрөмжид			ҮАзардалд	2022он	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1
2		Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	Хагас жил бүр	500	500.0		

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
3	Байгалийн гамшиг, түүнээс	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн хүрээнд	Жил бүр	-	-	2022он	
4	урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ. Химийн бодисоос үүсэх осол эрсдэл	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	Төслийн хүрээнд	Жил бүр	-	ҮАзардалд		

7.7 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

№	Хог хаягдлын ангилал /Болзошгүй сөрөг нөлөөлөл/	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	удаа	120.0	Жил бүр	120.0	2022 он	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд

№	Хог хаягдлын ангилал /Болзошгүй сөрөг нөлөөлөл/	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
2	Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг зайлуулж буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж засвар үйлчилгээг хийж байх, нийлүүлж буй бохир усны найрлагад хяналт тавих	Төслийн хүрээнд	удаа	250.0	Жил бүр	250.0	2022 он	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
3	Аюултай хог хаягдлын хуримтлал үүсэх, ахуйн хог хаягдалтай холилдох	Химийн бодис, шингэн хог хаягдал асгарсан тохиолдолд тухай бүрд нь арилгаж байх материалыг /элс, хаягдал зөөлөн даавуу гэх мэт/ нөөцлөн бэлдэх	Төслийн хүрээнд	удаа	-	Жил бүр	-		Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд,
4	Хийн хаягдал гарч агаар орчин бохирдож болзошгүй	Химийн бодисын/фреон сав баглаа боодол гэх мэт бодисоор бохирдсон аюултай хог хаягдлууд.	Төслийн хүрээнд	удаа	-	Жил бүр	-		Агаарын чанарын тухай хууль

7.8 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Ганган хос вансэмбэрүү” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын хуулиудын дагуу “Ганган хос вансэмбэрүү” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Ганган хос вансэмбэрүү” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, төг /мян.төг/	Тайлбар	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	2	3	4	5	6	7	8	
Агаарын чанар								
1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Үйлдвэр, агуулахын байранд 2 цэг	Хагас жилд 1	Жилд 2	25.0	80.0	Нийт 2 цэгээс	MNS 4585-2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм
Усны чанар								
2	Унд ахуй, технологи, бохир усны хяналтын шинжилгээ	Гүний худгийн ус, технологид хэрэглэж байгаа ус, хаягдал ус,	Хагас жилд 1	Жилд 2	35.0	90.0	Бохир уснаас дээжлэх	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 13.060.50 Усны чанарын стандарт
Хөрсний бохирдол								
3	Хөрсний төлөв байдал, бохирдол:	Үйлдвэрийн хашаан дахь талбайгаас 2 цэг сонгох	Хагас жилд 1	Жилд 2	40.0	100.0	2 цэгт, 2 дээж (Хөрсний химийн шинжилгээ 1дээж-20.0₮, хүнд металлын шинжилгээ 1дээж – 20.0₮)	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
Нийт дүн					270.0			

